

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД У.ХҮРЭЛСҮХИЙН БИЗНЕС ЭРХЛЭГЧИДТЭЙ ХИЙСЭН “BUSINESS BREAKFAST” УУЛЗАЛТЫН АСУУЛТ, ХАРИУЛТ

Д/д	Иргэн /байгууллага	Асуулт	Хариулт
1	Марио нью райл лайн Жамбалдорж	Монгол Улсын Тээвэр зуучлалын салбарын хөгжил таны бодлоор?	<p>Манай Улс газар зүйн байршлын давуу талаа ашиглан дэлхийн худалдааны томоохон оролцогч хөрш хоёр орны хоорондын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны гүүр болох замаар эдийн засгаа хурдацтай хөгжүүлэх боломж байна.</p> <p>Монгол Улсын хэмжээнд тээвэр зуучлалын 340 орчим аж ахуй нэгж бүртгэлтэй байгаагаас 160 орчим компани одоо үйл ажиллагаа явуулж байна. Монгол Улс 2017 онд дэлхийн 163 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 10.5 тэрбум америк доллар, үүнээс экспорт 6.2 тэрбум америк доллар, импорт 4.3 тэрбум америк долларт хүрсэн үзүүлэлт гарсан /Үндэсний статистикийн хорооноос гарсан тоо/ энэ нь өмнөх онтой харьцуулахад өссөн үзүүлэлт юм. Ийнхүү өсөлттэй гарахад тээвэр зуучлалын компаниудын үзүүлсэн хувь нэмэр их гэж үзэж байна. Цаашид тээвэр зуучийн үйл ажиллагааг сайжруулах хүрээнд төрөөс дэд бүтэц, улс хоорондын худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааг дэмжсэн үйл ажиллагааг хийхээр ажиллаж байна.</p> <p>Тухайлбал: Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутаг дэвсгэрт “Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд авто зам, гүүрэн байгууламж, хамгаалалтын хашааны барилга угсралтын ажил, эрчим хүчний шугам, 16 Квт-ын дэд станцын барилгын ажил, цэвэр усны шугамын, холбоо интернетийн шилэн кабелийн, цахилгаан эрчим хүчний шугам, 110 Квт-ын дэд станцыг барьж байна.</p>
2	Цагдуултайн Ундрага ХХК Мөнгөншагай	Уул уурхайн бизнесийн мэргэжлийн болгох талаар ямар чиглэл барих вэ? Нөхөн сэргээлт бичил уурхай нэрээр ухаж салбарын үнэлэмжийг унагаж байна. Орон нутагт зөвшөөрөл олгодгийг зогсоох хэрэгтэй.	<p>Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл авсан компани үйл ажиллагаа явуулахгүй тусгай зөвшөөрлөө бие биендээ арилждаг байдлыг зогсоож, уул уурхайн салбарт мэргэшсэн аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулдаг болгох зорилгоор ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг өргөдөл болон сонгон шалгаруулалтаар олгодог байсныг</p> <ul style="list-style-type: none"> ➢ хайгуулын тусгай зөвшөөрлийг зөвхөн сонгон шалгаруулалтаар олгох, ➢ ашиглалтын тусгай зөвшөөрлийг зөвхөн өөрийн эзэмшиж буй хайгуулын тусгай зөвшөөрлийг ашиглалт болгох үед өргөдлийг хүлээн зөвшөөрч түүнээс бусад тохиолдолд сонгон шалгаруулалтаар олгодог болох хуулийн нэмэлт, өөрчлөлтийг холбогдох хуульд нь тусгаж өгсөн. <p>Түүнчлэн, ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй этгээдийг шууд болон шууд бусаар эзэмшдэг этгээд нь өөрийн хувьцаа, хувь эзэмшил, саналын эрхээ бусдад борлуулах замаар тусгай зөвшөөрлийн эцсийн эзэмшигч өөрчлөгдөх тохиолдолд холбогдох татварыг төлөх</p>

			ёстойг хуульчилж, энэ үүргээ биелүүлээгүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлах эрх зүйн зохицуулалтыг бий болгосон.
3	Сүлдэт майнинг ХХК захирал Гангаалхам	2018 онд төрөөс уул уурхайн салбарт баримтлах бодлогын талаар?	Газрын тос боловсруулах үйлдвэр, Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр, Нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэр барих мөн Тавантолгойн ордыг иж бүрэн ашиглах зэрэг уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт хэрэгжиж байгаа томоохон төсөл хөтөлбөрүүдийн ажлыг эрчимжүүлэх тал дээр голлон анхаарч ажиллана.
4	Грийт Контакт	Татварын таатай орчин бүрдүүлэх боломжийн талаар?	Өнөөгийн нөхцөл байдалд тулгуурлан хөрөнгө оруулалт, бизнесийн орчин, жижиг дунд үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, татвар төлөгчийн эрх ашгийг хамгаалах, татварын ил тод, тэгш шударга байдлыг хангах, татвар төлөхөөс зайлсхийх явдалтай тэмцэх олон улсын шинэлэг зарчмуудыг нэвтрүүлэх, хуулийн ойлгомжгүй, хийдэлтэй заалтуудыг цэгцлэх, татварын албаны чадавхийг бэхжүүлэх зорилгоор Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагалдах бусад хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулж, олон нийтийн хэлэлцүүлэгт шилжүүлэхээр ажиллаж байна.
5	БОЖСС косметик ХХК	Гоо сайхны барааны гаалийн татвар, МУ-ын хууль 2-ын зөрчил?	Монгол Улсын Их Хурлын 1999 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 27 дугаар тогтоолоор импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээг тогтоосон болно. Тус тогтоолын хавсралтын 33 дугаар бүлэгт багтах эфирийн тос, давирхайн үнэрт охь, үнэртэн, гоо сайхан, ариун цэврийн бэлдмэлийн гаалийн албан татварын хэмжээг 5 хувь байхаар тогтоосон байна
6	Алтан Оршихуй корпораци Б.Билгүдэй	Бизнес эрхлэгчдэд таатай орчин бүрдүүлэх асуудал дээр хэрхэн ажиллах вэ?	<p>Бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжүүдэд хамгийн чухал зүйл бол таамаглаж болохуйц, бизнесийн үйл ажиллагаагаа 5-10 жилээр төлөвлөж болохуйц тогтвортой, таатай эдийн засгийн орчин бүрдүүлэх явдал байгаа. Иймд Засгийн газраас нэн тэргүүнд макро эдийн засгийн зохистой, тогтвортой орчин бүрдүүлэх замаар бизнес эрхлэгчдэд учирч буй тодорхой бус байдлын эрсдлийг бууруулах бодлого барьж байна.</p> <p>Бизнес эрхлэгчдийн дунд хийсэн судалгаанаас харахад манай улсад засаглал, бизнес явуулах эрхзүйн орчин, татварын орчин бүхэлдээ тааруу үнэлэгдсэн байна. Судалгаанд оролцогчдын 90 орчим хувь нь бизнест хамгийн их тулгамдаж байгаа хүндрэлийг санхүүжилттэй холбоотой асуудлууд, тодруулбал: банкны зээлийн шалгуур өндөр, олдоц тааруу, хүү өндөр, барьцаа хөрөнгө их шаарддаг байдал гэж тодорхойлсон байсан. Түүнчлэн, татвар, мэргэжлийн хяналт зэрэг төр засгийн байгууллагуудад хүнд суртал, авлига байгаа нь бизнесийн орчныг муутгаж байна гэж дүгнэсэн байсан.</p> <p>Иймээс бизнес эрхлэгчид, ялангуяа жижиг, дунд бизнес эрхлэгчид банкнаас хямд эх үүсвэр авах боломж нөхцөлийг бүрдүүлэх, хоёрдугаарт төрийн албаны үйлчилгээг цахимжуулж,</p>

			бизнес эрхлэгчдэд зардал, чирэгдэл багатай, түргэн, шуурхай болгох ажил нэн чухал байгаа. 2018 онд төсвийн алдагдлын хэмжээг багасгаж, дотоодоос авах санхүүжилтийн хэмжээг бууруулах замаар хувийн хэвшлийн эх үүсвэрийг дэмжинэ. Мөн Төрийн үйлчилгээг цахимжуулж, төрөөс үзүүлдэг 150 гаруй нэр төрлийн мэдээлэл, лавлагаа авах үйлчилгээг цахимжуулах ажлыг хийнэ.
7	Алтан Оршихуй корпораци Б.Билгүдэй	Улсын эдийн засгийн бодит өсөлтийг хэрхэн бий болгох вэ?	2017 онд эдийн засгийн уналтыг зогсоож, өсөлтийг сэргээж чадсан жил боллоо. Цаашид эдийн засгийн бодит өсөлтийг нэмэгдүүлэх, улмаар тогтвортой хадгалах зорилт манай Засгийн газрын өмнө тавигдаж байна. Иймд манай Засгийн газрын зүгээс 2020 он хүртэлх хугацаанд боломжтой, дорвитой, томоохон төслүүдийг бодитой хэрэгжүүлж иргэдээ ажилтай, орлоготой болгох, улсынхаа эдийн засгийг тэлэх нөхцөлийг бүрдүүлнэ. Тухайлбал, Манай улс шатахууны импортод жилд 1 тэрбум ам.долларыг, ган, төмрийн импортод жилд 200 сая ам.долларыг гадагшаа алдаж байна. Эдгээр ам.долларын гадагшлах урсгалыг зогсоох, эдийн засгийн дархлааг нэмэгдүүлэх зорилгоор Газрын тос боловсруулах, Ган, арматур үйлдвэрлэх үйлдвэрийг барина. Мөн ТЭЗҮ нь хийгдсэн болон хийгдэж байгаа томоохон төслүүдийн хөрөнгө оруулагчдыг яаралтай сонгон, барилгын ажлыг ойрын хугацаанд эхлүүлнэ. Цөөн нэр төрлийн бүтээгдэхүүн, цөөн тооны худалдан авагч орнуудаас хэт хамааралтай байдлыг бууруулна.
8	Глобал Инвест ХХК Т.Баттулга	Хувийн хэвшилтэй хамтран ажиллах талаар?	2018 онд Засгийн газрын дотоодоос авах санхүүжилтийн хэмжээг бууруулах замаар хувийн хэвшлийн санхүүжилт олох боломжийг нэмэгдүүлнэ. Төрийн үйлчилгээг цахимжуулж, төрөөс үзүүлдэг 150 гаруй нэр төрлийн мэдээлэл, лавлагаа авах үйлчилгээг цахимжуулах ажлыг хийнэ. Мөн Төрийн хяналт, шалгалтыг бууруулах замаар хувийн хэвшлийг дэмжиж ажиллана. Зам, гүүр, барилга, эрчим хүч, уул уурхай гэх мэт дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажилд хувийн хэвшлийг түлхүү оролцуулах зарчим баримтална.
9	Сүкэ Холдинг У.Батсүх	Валютын ханшийн талаарх мэдээлэл, аль болох тогтвортой байдал хэрэгтэй байна. 2018 онд улс орны эдийн засаг тогтвортой байх уу?	Ойрын жилүүдэд эдийн засгийн тогтвортой байдлыг хангах асуудал нь эн тэргүүний зорилт тул валютын ханш, төсвийн алдагдал, инфляци, өрийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор төсвийн бодлогын реформуудыг хийж, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, төсвийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээнүүдийг авч байна. 2017 онд Монгол Улсын гадаад валютын албан нөөц 3.0 тэрбум ам.долларт хүрсэн бол төлбөрийн тэнцэл 1.0 тэрбум ам.доллар давсан ашигтай гарсан. Иймээс 2018 онд валютын ханшийн савалгаа үүсгэхгүй, тогтвортой барих боломж бүрдсэн гэдгийг хэлье. 2018 онд валютын ханшийг тогтвортой байлгана.
10	Урлахуйн хишиг ХХК	Манай компани гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Бараа материалын 90 хувийг	Энэ онд зах, худалдааны төвүүдийг НӨАТ-ын системд холбох ажлыг бүрэн хийж дуусгах төлөвлөгөөтэйгээр ажиллаж байна. Хуулиар НӨАТ-ын баримт өгөхгүй байгаа аж ахуйн нэгж, иргэдэд хариуцлага тооцох зохицуулалттай. Иймд танай компанийн зүгээс Татварын албанд уг зөрчлийн талаар мэдэгдэж, холбогдох зөрчлийг арилгуулах боломжтой.

		захаас авдаг тул НӨАТ-ын баримт өгдөггүй. Иймээс борлуулалтаасаа НӨАТ төлөхөд хүндрэлтэй байдаг. НӨАТ-ын хөнгөлөлт өгөх боломжтой юу?	
11	Монланс	Дүүргүүдийн татварын албанаас зарим компаниудын дансыг хаагаад жил болж байна. ААН-үүдээ ингэж хүчээр хаах хэрэггүй. Дээр нь 7 төрлийн татварт хариу өгнө үү?	Одоогийн мөрдөгдөж байгаа хуулиар татвар төлөгчийн хугацаанд нь төлөөгүй татварыг үл маргах журмаар болон эд хөрөнгө, цалин хөлс, бусад орлогоос гаргуулах, шүүхэд нэхэмжлэл гаргах гэсэн дарааллаар хурааж байгаа. Мөн хуулинд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас татвараа хугацаанд нь төлж чадахааргүй бол татвар төлөгчийн бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн тухайн татварын албаны даргын тушаалаар хугацааг нь 60 хүртэл хоногоор нэг удаа сунгаж болох хуулийн зохицуулалттай байна. Татварын ерөнхий хуулийн төсөлд татвар төлөх хугацааг урт хугацаагаар сунгах боломжийг бүрдүүлэхээр тусгасан болно.
12	Тулга гоёл трэйд	Манай компани өөрийн хөрөнгөөр алт цэвэршүүлэх сонирхолтой байгаа боловч эрхзүйн орчин тодорхой бус байна. Засгийн газрын байр суурь, хамтарч ажиллах боломж?	Монголбанк 2017 онд 20 тонн алт худалдан авсан бөгөөд цаашид 20-25 тонн болохоор байгаа. МонголУлсын олборлон баяжуулж байгаа алт нь дунджаар 85.0 хувийн агуулгатай бөгөөд түүнийг олон улсын зах зээлд борлуулахын тулд 99.99 хувийн цэвэр алт болгох шаардлагатай байдаг. Манай улс ОХУ, Их Британи, Япон зэрэг улсад алтаа цэвэршүүлж ирсэн бөгөөд сүүлийн жилүүдэд Швейцарь улсад цэвэршүүлж байна. Гадаадад алтаа цэвэршүүлэхэд тээвэр, даатгал, хамгаалалтын зардал гээд зардлууд гардаг. Нөгөө талдаа алт цэвэршүүлэх үйлдвэрийн байгаль орчинд үзүүлэх нөлөө, стандартын шаардлага гээд олон зүйлийг судлах шаардлагатай байгаа тул Монголбанк, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, “Эрдэнэс Монгол” ХХК, Үнэт металлын сорьцын хяналтын газар хамтран судалгаа хийж байна.
13	Монгол Ардын Нам	Бизнес эрхлэгч нарт татвараас чөлөөлөх санал байна уу?	Дэлхийн банктай Сангийн яам татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэмжээг 2016 оны түвшингөөс 2019 онд 10 хувиар бууруулахаар тохиролцсон тул татварын аливаа хөнгөлөлт, чөлөөлөлтийг дэмжихэд хүндрэлтэй байгаа. Гэвч, татварын шууд хөнгөлөлт, чөлөөлөлтөөс илүү татвар төлөгчийн татварын зардлыг бууруулах чиглэлээр холбогдох хуулийн өөрчлөлтийг хийж байгаа болно.
14	Рендер Бай ХХК	Татварын нэмэгдлийн талаар	Төсвийн орлогын тогтвортой эх үүсвэрийг бий болгох, иргэдийн орлогын ялгааг бууруулах, татварын тэгш, шударга байх зарчмыг хангах зорилгоор хувь хүний орлогын албан татварыг шатлалтай болгох, нөгөө талдаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ шинэчлэгдсэнтэй

			<p>уялдуулан татварын хөнгөлөлтийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд иргэдийн орлогын ялгаа буурах, татварын шударга тогтолцоо бий болоод зогсохгүй бага, дунд орлоготой иргэдийн татварын дарамт буурах болно. Түүнчлэн, бүх төрлийн хадгаламжийн хүүгийн орлогод татвар ногдуулах хуулийг өнгөрсөн оны 5 сарын 01-нээс дагаж мөрдөж байна.</p> <p>Мөн нийгэм, эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлдэг зарим төрлийн хэрэглээг хязгаарлахаар архи, тамхины онцгой албан татварыг үе шаттайгаар 2018 онд 10 хувь, 2019-2020 онд тус бүр 5 хувиар, импортын тамхинд ногдох гаалийн албан татварыг тус тус нэмэгдүүлсэн. Суудлын автомашины онцгой албан татварыг нэмсэн ингэхдээ хос тэжээлт автомашин, шингэрүүлсэн хийгээр ажилладаг автомашин, цахилгаан тэжээлт автомашины татварын хөнгөлөлтийг бууруулах, суудлын автомашины хөдөлгүүрийн багтаамж, насжилтаас хамааруулж онцгой албан татварын хэмжээг шинэчлэн тогтоосон.</p>
15	Хөгжлийн шийдэл ТББ	Байгууллагуудын НДШ-ын өөрчлөлтийн хор нөлөөллийн талаар?	<p>Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ ажил олгогч, даатгуулагчийн цалингаас тус бүр 7 хувиар тооцож, шимтгэл авдаг байсныг 2017 оны төсвийн тодотголоор хувь хэмжээг тус бүр 2,5 нэгж хувиар нэмэгдүүлж 9,5 хувь болгосон бөгөөд уг хуулийн өөрчлөлт 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Ингэж цалингаасаа төлөх шимтгэлийн хувь хэмжээ нэмэгдэх нь нийгмийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлэх боловч ажил олгогч, даатгуулагчид аль алинд нь дарамт үүсгэж байгаа тул дэмжихгүй байгаа. Энэ удаагийн ОУВС-тай хийх уулзалтаар сүүлд оруулсан татварын өөрчлөлтүүдийн талаар ярилцана.</p>
16	Байгууллагын даатгалын менежер Б.Мягмарханд	Монголд санхүүгийн тогтвортой байдлыг хангах талаар ямар арга хэмжээ авч цаашлаад тогтвортой байдлын зөвлөлд ямар зөвлөгөө зөвлөмж үүрэг даалгавар өгөх вэ? Банк дангаараа санхүүгийн зах зээлд ноёрхсоор байх уу? Түүгээр ч зогсохгүй эрсдэлээ ч мөн даатгалын компаниудад үүрүүлсээр байх уу?	<p>Банкуудын санхүүгийн байдлыг олон улсын стандартад нийцсэн аргачлалаар үнэн зөв тодорхойлох зорилготой Активын чанарын үнэлгээ хийж байгаа ба энэхүү үнэлгээний үр дүнд банкуудын төлбөрийн чадварт итгэх итгэл сайжирч, гадаад дотоодын хөрөнгө оруулалт татах боломж, зээл олголт нэмэгдэх төлөвтэй байна. Банкнаас бусад санхүүгийн салбарыг хөгжүүлэх арга хэмжээнүүдийг Сангийн яам гол зохицуулагч байгууллагууд болох Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанкттай хамтран авч байна. Үүнд хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийг сайжруулах, компанийн засаглалын сайн зарчмуудыг нэвтрүүлэх, эрсдэлийг бууруулах чиглэлийн арга хэмжээнүүд багтсан. Жишээ нь, хөрөнгийн зах зээлийг дэмжих хүрээнд Засгийн газрын үнэт цаасны зарим хэсгийг Хөрөнгийн биржээр дамжуулан арилжаалах, гадаадын хөрөнгө оруулагчдын хөрөнгийн зах зээл дэх оролцоог сайжруулах хүрээнд олон улсын кастодианыг нэвтрүүлэх, хөрөнгө оруулагчдыг тогтмол мэдээллээр хангах, Хөрөнгийн биржийн арилжааны зарчмыг олон улсын жишигт нийцүүлэх зэрэг ажил хийж байна.</p> <p>Монгол Улсын Их Хурлаас 2016 онд баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал”-д Эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих хөгжлийн санхүүжилтийн болон санхүүгийн зах зээлийн зохистой тогтолцоог хөгжүүлнэ. Санхүүгийн зах зээлд банкны бус санхүүгийн байгууллагын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлж, арилжааны банк, хөрөнгийн зах</p>

			<p>зээл, даатгалын зах зээлийн эзлэх хувийг зохистой түвшинд хүргэнэ” гэж заасан. Энэ хүрээнд Сангийн яам, Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хороотой хамтран “Монгол улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” боловсруулж, 2017 оны 10 дугаар сард Засгийн газраар батлууллаа. Хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн салбарт хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээнүүдийг 2018-2025 онд хоёр үе шаттай авч хэрэгжүүлэхээр тодорхойлсон бөгөөд санхүүгийн салбарын эдийн засагт гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх, хөрөнгийн зах зээлийн санхүүгийн зах зээлд эзлэх хувь хэмжээг 12 хувьд хүргэн өсгөх, даатгалын зах зээлийн гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх, зээлийн хүүгийн дундаж түвшин 20 хувьтай байгааг 16 хувь хүртэл бууруулах болон бодлогын бусад арга хэмжээг багтаасан. Хөтөлбөрийг боловсруулахдаа ОУВС, Дэлхийн банкнаас улс орнуудын санхүүгийн салбарт үнэлгээ дүгнэлт өгөхөд баримталдаг Санхүүгийн салбарын үнэлгээний хөтөлбөрийн аргачлалаар хийсэн. Үүнд санхүүгийн салбартай холбоотой олон улсын 10 гаруй стандартын хувьд нийцтэй байдлын үнэлгээ хийж, санхүүгийн салбар бүрт тулгамдаад байгаа асуудлыг гаргаж ирсэн бөгөөд энэхүү үнэлгээнд үндэслэн цаашид авах бодлогын арга хэмжээнүүдээ тодорхойлсон. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж батлуулан хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр боловсруулахдаа санхүүгийн салбарын бүтцийг банкны салбар, даатгалын зах зээл, хөрөнгийн зах зээл, бичил санхүү, зах зээлийн дэд бүтэц, олон нийтийн санхүүгийн боловсрол, санхүүгийн хүртээмж, хадгаламжийн даатгал, санхүүгийн салбарын сайн засаглал гэсэн чиглэлүүдээр авч үзсэн. Үнэлгээний үр дүнгээс харахад банкны салбарын бодлого зохицуулалт, хөгжил олон улсын түвшинд харьцангуй ойртсон боловч банкнаас бусад санхүүгийн салбарын бодлого зохицуулалтын хувьд сайжруулах шаардлагатай олон зүйл байна. Эдгээр арга хэмжээг хөтөлбөрийн дагуу авч хэрэгжүүлснээр банкнаас бусад санхүүгийн салбар эн тэнцвэртэйгээр хөгжихөд дэмжлэг болно.</p>
17	МУИС-ХЗС, Оюутан, Алтанчимэг	Бизнесийн гараагаа эхлэхдээ хөрөнгө мөнгөө босгох зохицуулахад төрөөс хэрхэн дэмжих вэ?	<p>Засгийн газраас бизнесийн гараагаа эхэлж байгаа иргэдээ дараахь байдлаар санхүүжилт босгоход нь дэмжлэг үзүүлнэ.</p> <ol style="list-style-type: none"> 1. Засгийн газраас анхлан бизнес эрхэлж байгаа иргэдэд санхүүжилтээ босгох ажлыг Зээлийн Батлан даалтын сангаар дэмжих бололцоотой. Монгол Улсын “Зээлийн батлан даалтын сангийн тухай” хууль 2012 онд батлагдаж, тус сан байгуулагдсан. Сангийн үүсгэн байгуулагч нь Монгол Улсын Засгийн Газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбоо юм. Зээлийн Батлан Даалтын Сан нь барьцаа хөрөнгийн дутагдалтай Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд батлан даалт гаргах ашгийн төлөө бус байгууллага юм. Тус Сангийн зорилго

			<p>нь Шуурхай, ил тод, найдвартай үйлчилгээгээр Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжих, улмаар Монгол улсын эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулна.</p> <ul style="list-style-type: none"> ○ ЖДҮ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж нь зээлийн батлан даалт гаргуулах хүсэлтээ зээлээ судлуулах банкны салбар нэгжид гаргана. ○ Банк нь зээлийг судлаад зээлийн хорооны шийдвэр буюу зээл олгох дүгнэлтээ зээлийн холбогдох материалын хамт Зээлийн батлан даалтын санд ирүүлнэ. ○ Зээлийн батлан даалтын сан нь банкнаас ирсэн зээлийн дүгнэлтэд үндэслэн судлагаа хийж, батлан даалт гаргах шийдвэрээ банкинд хүргүүлнэ. ○ Банк нь зээлийн батлан даалтын сангийн батлан гаргах шийдвэрт үндэслэн батлан даалттай зээлийг зээлдэгчдэд олгоно. <p>2. Хөдөлмөр эрхлэлтийн сангаар дамжуулан хөнгөлөлттэй зээл олгох замаар дэмжих боломжтой.</p>						
18	Ану-Интернэшнл ХХК, Баярсайхан	Гадаадын хөрөнгө оруулалтын татах талаар ЗГ-аас санаачилж хийх боломжтой ажил юу вэ?	<p>Засгийн газар гадаадын хөрөнгө оруулалтын татах талаар дараахь чиглэлээр ажиллаж байна.</p> <ol style="list-style-type: none"> 1. Төсвийн алдагдал, гадаад өрийн хэмжээг бууруулж, эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх замаар Монгол Улсын зээлжих зэрэглэл, санхүүгийн сахилга батыг нэмэгдүүлж, хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээнэ. Ингэснээр Монголд оруулах хөрөнгө оруулалт нэмэгдэх боломжтой, 2. Томоохон төслүүдийг эрчимжүүлснээр үүнийг дагаад хөрөнгө оруулалт орох боломжтой, 3. Хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлээр дотоодод хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтыг зохион байгуулах, мөн гадны улсуудад зохион байгуулагдаж байгаа Хөрөнгө оруулагчдын уулзалтад оролцох замаар Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчны талаар бодитой мэдээллийг олгох, 4. Олон улсын нэр хүнд бүхий хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж, Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчин, боломжийн талаар мэдээллийг тогтмол өгөх, 5. Татвар болон хууль эрх зүйн орчныг тогтвортой байлгах нь гадаад талд эерэг дохио өгнө. 						
19	Юнайтэд Экспресс ХХК Гармаасүрэн	Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд Монголын засгийн газраас авч буй арга хэмжээ хөтөлбөрийн талаар?	<p>Монгол Улсын Засгийн Газраас аялал жуулчлалын салбарын хөгжлийг эрчимжүүлж, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн шат дараалласан бодлого, арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Тухайлбал:</p> <table border="1"> <thead> <tr> <th colspan="2">Зорилт</th> <th>Арга хэмжээ</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Дэд хөгжүүлэхэд:</td> <td>бүтцийг</td> <td>Зам тээврийн салбарын бодлогыг аялал жуулчлалын салбарын бодлоготой харилцан уялдуулах</td> </tr> </tbody> </table>	Зорилт		Арга хэмжээ	Дэд хөгжүүлэхэд:	бүтцийг	Зам тээврийн салбарын бодлогыг аялал жуулчлалын салбарын бодлоготой харилцан уялдуулах
Зорилт		Арга хэмжээ							
Дэд хөгжүүлэхэд:	бүтцийг	Зам тээврийн салбарын бодлогыг аялал жуулчлалын салбарын бодлоготой харилцан уялдуулах							

				Шинэ олон улсын нисэх онгоцны буудлыг ашиглалтанд оруулж, олон улсын нислэгийн тоо, чиглэлийг нэмэгдүүлэх замаар нислэгийн үнийн уян хатан байдлыг бий болгох
				Шинэ нисэх онгоцны буудлыг түшиглэн Аялал жуулчлалын чөлөөт бүсийг бий болгох
				Аялал жуулчлалын гол маршрутын авто зам дагуу аялагч жуулчдад зориулсан түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолборыг байгуулах
			Аялах жуулчлах нөхцлийг хөнгөвчлөхөд:	Цахим виз мэдүүлэх эрх зүйн орчинг бий болгох
				Хил орчмын бүс нутгуудад аялах жуулчдыг нэг удаагийн хуудсаар хил нэвтрүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх
				Бүлэг жуулчдад визний хөнгөлөлттэй нөхцлөөр үйлчлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх
			Бүсчлэн хөгжүүлэхэд:	Бүсчилсэн хөгжлийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх
				Орон нутагт өөр хоорондоо ялгаатай бүтээгдэхүүн, үйлчилгээ хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
				Сэдэвчилсэн аялал жуулчлалын цогцолбор байгуулахыг бодлогоор дэмжих
				Аймгуудад аялал жуулчлалын хөгжүүлэх хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх
				Орон нутгийн брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, гадаад, дотоодод сурталчлах
			Гадаад хамтын ажиллааг өргөжүүлэх, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд:	Торгоны замын аялал жуулчлалын хөтөлбөрийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцож, "Нүүдэлчдийн замаар аялахуй" аялал жуулчлалын брэндийг хөгжүүлэх
				ДАЖБ-тай хамтран Аялал жуулчлалын тандалт, судалгааны төвийг байгуулах
				"Цайны зам" аялал жуулчлалын төслийг хөрш орнуудтай хамтран хэрэгжүүлэх замаар гурван улсыг дамнасан аялал жуулчлалын шинэ брэнд бүтээгдэхүүн бий болгох
Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт "Аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг бүс нутгийн хэмжээнд дээшлүүлж, эрх				

			<p>зүйн таатай орчинг бүрдүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.” гэж тусгасан бөгөөд үүний тулд үйл ажиллагаануудыг авч хэрэгжүүлэхээр тусгажээ. Үүнд:</p> <table border="1" data-bbox="741 259 2001 922"> <thead> <tr> <th data-bbox="741 259 825 310">д/д</th> <th data-bbox="825 259 2001 310">Зорилт</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="741 310 825 412">1.</td> <td data-bbox="825 310 2001 412">Аялал жуулчлалыг хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх, олон улсын аялал жуулчлалын сүлжээнд нэгдэх, бүтээгдэхүүн, дэд бүтцийг хөгжүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах цогц бодлого хэрэгжүүлнэ.</td> </tr> <tr> <td data-bbox="741 412 825 514">2.</td> <td data-bbox="825 412 2001 514">Үндэсний зан заншил, уламжлал, түүх, соёл, унаган байгаль, нүүдэлчин ахуйг түшиглэсэн аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлж, нийслэл, аймаг, бүс нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалын дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.</td> </tr> <tr> <td data-bbox="741 514 825 651">3.</td> <td data-bbox="825 514 2001 651">“Бурхан халдун”, “Хорго-Тэрх”, “Хамарын хийд”, “Отгонтэнгэр”, “Хар-Ус”, “Хөвсгөл”, “Хархорин” зэрэг байгалийн үзэсгэлэнт, өвөрмөц тогтоц бүхий газар нутгийг түшиглэсэн түүхэн болон төрөлжсөн аялал жуулчлалын төв, цогцолборыг төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаадын хөрөнгө оруулалтаар байгуулахыг бодлогоор дэмжинэ.</td> </tr> <tr> <td data-bbox="741 651 825 753">4.</td> <td data-bbox="825 651 2001 753">Монгол Улсын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг гадаад улс оронд сурталчлах, маркетингийн үйл ажиллагааг төрөөс дэмжиж, жуулчин хүлээн авах хүчин чадлыг сайжруулж, гадаад жуулчдын тоог нэмэгдүүлнэ.</td> </tr> <tr> <td data-bbox="741 753 825 820">5.</td> <td data-bbox="825 753 2001 820">Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу байгальд ээлтэй зогсоол, үйлчилгээний төвүүдийг олон улсын стандартад нийцүүлэн байгуулахыг дэмжинэ.</td> </tr> <tr> <td data-bbox="741 820 825 922">6.</td> <td data-bbox="825 820 2001 922">Олон улсын аялал жуулчлалын салбарын хөгжлийн чиг хандлага, туршлага, стандартыг нэвтрүүлэх, нутагшуулах, олон талт төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий судалгаа шинжилгээний орон тооны бус зөвлөл, нэгжийг байгуулна.</td> </tr> </tbody> </table>	д/д	Зорилт	1.	Аялал жуулчлалыг хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх, олон улсын аялал жуулчлалын сүлжээнд нэгдэх, бүтээгдэхүүн, дэд бүтцийг хөгжүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах цогц бодлого хэрэгжүүлнэ.	2.	Үндэсний зан заншил, уламжлал, түүх, соёл, унаган байгаль, нүүдэлчин ахуйг түшиглэсэн аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлж, нийслэл, аймаг, бүс нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалын дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	3.	“Бурхан халдун”, “Хорго-Тэрх”, “Хамарын хийд”, “Отгонтэнгэр”, “Хар-Ус”, “Хөвсгөл”, “Хархорин” зэрэг байгалийн үзэсгэлэнт, өвөрмөц тогтоц бүхий газар нутгийг түшиглэсэн түүхэн болон төрөлжсөн аялал жуулчлалын төв, цогцолборыг төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаадын хөрөнгө оруулалтаар байгуулахыг бодлогоор дэмжинэ.	4.	Монгол Улсын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг гадаад улс оронд сурталчлах, маркетингийн үйл ажиллагааг төрөөс дэмжиж, жуулчин хүлээн авах хүчин чадлыг сайжруулж, гадаад жуулчдын тоог нэмэгдүүлнэ.	5.	Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу байгальд ээлтэй зогсоол, үйлчилгээний төвүүдийг олон улсын стандартад нийцүүлэн байгуулахыг дэмжинэ.	6.	Олон улсын аялал жуулчлалын салбарын хөгжлийн чиг хандлага, туршлага, стандартыг нэвтрүүлэх, нутагшуулах, олон талт төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий судалгаа шинжилгээний орон тооны бус зөвлөл, нэгжийг байгуулна.
д/д	Зорилт																
1.	Аялал жуулчлалыг хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх, олон улсын аялал жуулчлалын сүлжээнд нэгдэх, бүтээгдэхүүн, дэд бүтцийг хөгжүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах цогц бодлого хэрэгжүүлнэ.																
2.	Үндэсний зан заншил, уламжлал, түүх, соёл, унаган байгаль, нүүдэлчин ахуйг түшиглэсэн аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлж, нийслэл, аймаг, бүс нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалын дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.																
3.	“Бурхан халдун”, “Хорго-Тэрх”, “Хамарын хийд”, “Отгонтэнгэр”, “Хар-Ус”, “Хөвсгөл”, “Хархорин” зэрэг байгалийн үзэсгэлэнт, өвөрмөц тогтоц бүхий газар нутгийг түшиглэсэн түүхэн болон төрөлжсөн аялал жуулчлалын төв, цогцолборыг төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаадын хөрөнгө оруулалтаар байгуулахыг бодлогоор дэмжинэ.																
4.	Монгол Улсын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг гадаад улс оронд сурталчлах, маркетингийн үйл ажиллагааг төрөөс дэмжиж, жуулчин хүлээн авах хүчин чадлыг сайжруулж, гадаад жуулчдын тоог нэмэгдүүлнэ.																
5.	Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу байгальд ээлтэй зогсоол, үйлчилгээний төвүүдийг олон улсын стандартад нийцүүлэн байгуулахыг дэмжинэ.																
6.	Олон улсын аялал жуулчлалын салбарын хөгжлийн чиг хандлага, туршлага, стандартыг нэвтрүүлэх, нутагшуулах, олон талт төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий судалгаа шинжилгээний орон тооны бус зөвлөл, нэгжийг байгуулна.																
20	ҮХОГ Хөрөнгө оруулалтын газрын захирал ВаХ	Монголын топ 100-наас ядаж томоохон 10 компанийг хөрөнгийн зах зээлд хувьцаагаа гаргахад төрөөс дэмжиж ажиллах ямар бодлого баримталж байгаа вэ? Б)Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй нээлттэй хувьцаат	<p>Монголын компаниуд үнэт цаасаа олон нийтэд нээлттэй арилжих боломж нээлттэй байгаа. Үнэт цаасаа олон нийтэд нээлттэй арилжаалахад компаниуд Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөл авах ёстой байдаг ба компаниуд үнэт цаасаа олон нийтэд санал болгож Хорооноос зөвшөөрөл авах ажиллагааг хөнгөвчлөх тал дээр Засгийн газраас Хороонд санал тавьж хамтран ажиллаж байна. Компаниуд хөрөнгийн зах зээлд гарч нээлттэй хувьцаат компани болсноор урт хугацааны найдвартай санхүүжилт татах хамгийн боломжит аргад тооцогддог. Энэхүү арга нь нээлттэй байгаа.</p> <p>(Б)Хөрөнгийн бирж дээрх нээлттэй хувьцаат компаниуд бол аль хэдийн олон нийтэд хувьцаагаа арилжсан, хэрэгцээт санхүүжилтээ татсан компаниуд. Тийм болохоор эдгээр компаниудыг дэмжиж ажиллана гэхээсээ илүүтэйгээр эдгээо компаниудын хариуцлагыг өндөржүүлэх шаардлагатай байна. Учир эдгээр компанид оруулсан хөрөнгө жижиг хувьцаа эзэмшигчдийн буюу ард иргэдийн мөнгө учир Сангийн яамнаас эдгээр компаниудын хариуцлагын тогтолцоог өндөржүүлэх, мэдээлэл, тайлагнал ил тод байдлыг дээшлүүлэх</p>														

		компаниудаа хэрхэн дэмжиж ажиллах вэ? В)Хөрөнгийн зах зээлийг цаашид хэрхэн яаж хөгжүүлэхээр төлөвлөж байгаа вэ?	зэргээр холбогдох арга хэмжээг бодлогын баримт бичигт суулган холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. Санхүүгийн зохицуулах хорооноос давхар бүртгэлийн журмыг баталсантай холбогдуулан “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК буюу Сангийн яамны 100%-ийн харьяа байгууллагын биржийн бүртгэлийн журмыг шинэчилж ажиллаж байна. Ингэснээр хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй нээлттэй хувьцаат компаниуд маань нэмэлт хувьцаа гаргах, гадаад улсын хөрөнгийн бирж дээр давхар бүртгэгдэх замаар нэмэлт санхүүжилт татах боломжийг олгохоор ажиллаж байна. Мөн гадаад улсад бүртгэлтэй компани манай улсын хөрөнгийн бирж дээр бүртгэгдэн иргэд олон нийт хувьцааны арилжаанд оролцох, мөн худалдан авсан хувьцааныхаа ногдол ашиг өгөөжийг хүртэх боломжийг олгож байна. (В) Монгол Улсын Засгийн газраас “Санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” –ийг баталсан. Энэхүү хөтөлбөрт тусгагдсанаар хөрөнгийн зах зээлийг 2018-2021, 2021-2025 он гэх зэргээр үе шаттайгаар хөгжүүлэхээр тусгасан. Энэхүү хөтөлбөрт зохицуулалтын орчинг сайжруулах, компаниудад санхүүжилт татах боломж нөхцлийг хөнгөвчлөх, нөгөө талдаа иргэд хөрөнгө оруулагчдыг хөрөнгийн зах зээл дээр хөрөнгө оруулалт хийх боломж нөхцлийг сайжруулах, хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийг сайжруулах зэрэг зорилтыг тавьж ажиллаж байна.
21	Нэмүү өртгийн сүлжээ бизнес бэлтгэх төвийн захирал М.Янжмаа	Бичил бизнес эрхлэгчдийн цаашдын хөгжлийн талаар кластераар хөгжих талаар?	Төр засгийн зүгээс уул уурхайн болон бусад томоохон төслүүдийг хөдөлгөх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар түүнийг дагасан ханган нийлүүлэлт, жижиг дунд үйлдвэрлэлийг бий болгох, өөрөөр хэлбэл жижиг дунд үйлдвэрлэлийн худалдан авалт, зах зээлийг бий болгох чиглэлд бодлого баримтлан ажиллаж байна. Томоохон төсөл, хөтөлбөрүүдийг дагасан жижиг дунд, үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх бодлогыг Эдийн засгийг сэргээх хөтөлбөрт тусган хэрэгжүүлж байна. Мөн жижиг, дунд үйлдвэрлэлийг дотоодын худалдан авалтын бодлого, санхүүжилтийн бүхий л төрлөөр дэмжих арга хэмжээг Засгийн газраас хэрэгжүүлж байна. Тухайлбал, Засгийн газрын 2017 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар 2017 онд худалдан авах ажиллагаа явуулахдаа дотоодын аж ахуйн нэгж, үйлдвэрлэгчдээ давуу эрх тооцон шалгаруулсныг сайшааж, цаашид энэ жишгээр ажиллахыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгаж дотоодын худалдан авалтыг нэмэгдүүлэх бодлого баримталж ажилласан. Цаашид энэ чиглэлийн бодлогыг үргэлжлүүлж дотоодын үйлдвэр эрхлэгчдийг Төр засгийн зүгээс дэмжин ажиллана. Засгийн газраас олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын хөнгөлөлттэй зээл, тусламж, төсвийн хөрөнгө оруулалт, Хөгжлийн банкны санхүүжилтээр жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжин ажиллаж байна. Тухайлбал, 2017 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 700 гаруй нарийн ногооны хүлэмжийн аж ахуйг шинээр бий болгож ажилласан бол Хөгжлийн банкны санхүүжилтээр хуурай сүүний үйлдвэрүүдийг санхүүжүүлээд байна. Цаашид эдгээр төрлийн санхүүжилтийг

			<p>эрчимжүүлж ажиллана. Мөн уул уурхайн томоохон компаниуд үйл ажиллагаа явуулж байгаа тухайн орон нутгийн аж ахуйн нэгж, иргэдээс тодорхой ханган нийлүүлэлтийг хангах хууль эрхзүйн орчныг бий болгож тухайн аймгийн зүгээс хэрэгжилтэд хяналтыг тогтмол хийн ажиллаж байна. Түүнчлэн жилийн орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй, газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл болон түүнд холбогдох туслах үйл ажиллагаа, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нэхмэлийн болон хувцас үйлдвэрлэл, барилгын материалын үйлдвэрлэл эрхлэгчдийн тухайн салбарт явуулсан үйл ажиллагаанаас олсон орлогод ногдох албан татварыг 90 хувиар хөнгөлөхөөр Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулан мөрдөж байна.</p>
22	Nandinway захирал Нандинчимэг	<p>ЖДБ эрхлэгч эмэгтэйчүүдээ хэрхэн дэмжин ажилладаг вэ? Төрөөс ямар дэмжлэг үзүүлдэг вэ?</p>	<p>Өнөөгийн нөхцөл байдалд тулгуурлан хөрөнгө оруулалт, бизнесийн орчин, жижиг дунд үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, татвар төлөгчийн эрх ашгийг хамгаалах, татварын ил тод, тэгш шударга байдлыг хангах, татвар төлөхөөс зайлсхийх явдалтай тэмцэх олон улсын шинэлэг зарчмуудыг нэвтрүүлэх, хуулийн ойлгомжгүй, хийдэлтэй заалтуудыг цэгцлэх, татварын албаны чадавхийг бэхжүүлэх зорилгоор Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагалдах бусад хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулж, олон нийтийн хэлэлцүүлэгт шилжүүлэхээр ажиллаж байна.</p> <p>Ер нь бол жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд бага хүүтэй, урт хугацаатай зээлийн асуудал байнга тавигдсаар ирсэн. Энэ хүрээнд жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаар дамжуулан 2009-2016 онуудад улсын хэмжээнд 745,45 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Жил бүр олгож буй хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр нь нийт зээлийн хэрэгцээний 10 хүрэхгүй хувийг хангаж байна.</p> <p>Олгосон зээлийн 83,5 хувийг эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлэх, тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулсан ба тухайн аж ахуйн нэгжийн ажлын байр, үйлдвэрлэлийн хүчин чадал нь нэмэгдсэн, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлсэн, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгосон, зах зээлээ өргөтгөснөөр борлуулалтын орлого нь дунджаар 20 - 30 хувиар нэмэгдсэн гэсэн дүн мэдээ байна.</p> <p>Тусгай сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлээд байна. Энэ хууль батлагдах хүртэлх хугацаанд “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас санхүүжүүлэх хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах түр журам”-ыг Засгийн газрын 2016 оны 138 дугаар тогтоолоор батлуулсан.</p> <p>Цаашид:</p> <ul style="list-style-type: none"> • Жилийн орлого нь 1,5 тэрбум төгрөгөөс бага орлоготой аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 1 хувь болгон бууруулах;

			<ul style="list-style-type: none"> • Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг зээлийн эрсдэлээс хамгаалах зорилгоор Зээлийн эрсдлийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх; • Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны эрх зүйн орчныг бий болгож тогтолцоог боловсронгуй болгох; • Хөдөө орон нутаг, алслагдсан бүс нутагт бизнес эрхлэлтийг дэмжих "Бүсийн хөнгөлөлтийн" бодлого хэрэгжүүлэх; • Зээлийн батлан даалт болон хөрөнгийн барьцааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох замаар жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх; • ЖДҮ-ийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, нэмүү өртөг шингэсэн худалдаа, үйлдвэр, үйлчилгээ, тээвэр ложистикийн сүлжээг цогцоор нь байгуулж кластерын зарчмаар төлөвлөн хэрэгжүүлэх; • ЖДҮ-ийн хүний нөөцийг сургах, давтан сургах, үйлдвэр дээрх сургалтыг тогтолцоог хөгжүүлэх; • Шинжлэх ухааны байгууллагуудын бүтээсэн шинэ техник технологийг жижиг, дунд үйлдвэрүүдэд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх; • ЖДҮ-ийг санхүүгийн эх үүсвэрээр дэмжих чиглэлээр төр, хувийн хэвшлийн хамтарсан санхүүжилтийн дэд сан бий болгох, санхүүгийн дэмжлэгийн төрлийг нэмэгдүүлэх; • ЖДҮ эрхлэгчид, өрхийн аж ахуй, бичил бизнес эрхлэгчдэд зориулсан таатай нөхцөл бүхий "Итгэлийн зээл" олгох бодлого баримтална; <p>Бизнесийн орчин дахь төрийн оролцоог багасгаж, төрийн үндэсний үйлдвэрийн худалдан авалтыг нэмэгдүүлэх.</p>
23	Түмэн нислэг трэйвэл Ангараг	Гарааны бизнес эрхлэгч залуусаа төр нь дэмжээд татварын уян хатан бодлого байж болохуу ядаж эхний жил өндийтэл нь татвараар дарамтлахгүй дэмжээд өгөөч энэ тал дээр ямар бодолтой байна вэ?	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд 2016.02.05-ны өдөр орсон нэмэлт өөрчлөлтөөр Улаанбаатар хотоос 550 км-ээс хол байршилтай аймаг, суманд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийг 50 хувиар, 1000 км-ээс хол алслагдсан аймаг, суманд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийг 90 хувиар хөнгөлж байна. Мөн бизнесийн орчин, жижиг дунд үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, татвар төлөгчийн эрх ашгийг хамгаалах зохицуулалтыг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгаж байгаа болно.
24	Saifu llc Уянга	ЖДБ эрхлэгчдийг ямар бодлогоор дэмжих вэ?	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хүрээнд 2018 онд дараах бодлогыг хэрэгжүүлнэ. -Аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдээ татварын тогтвортой бодлогоор дэмжин татварын тогтолцоог энгийн, ойлгомжтой, төвөг чирэгдэл багатай, тэгш шударга болгоход чиглэн

			<p>ажиллана. Тухайлбал, жилийн орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй, газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл болон түүнд холбогдох туслах үйл ажиллагаа, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нэхмэлийн болон хувцас үйлдвэрлэл, барилгын материалын үйлдвэрлэл эрхлэгчдийн тухайн салбарт явуулсан үйл ажиллагаанаас олсон орлогод ногдох албан татварыг 90 хувиар хөнгөлөхөөр Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлтийг мөрдөнө.</p> <p>- Засгийн газраас олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын хөнгөлөлттэй зээл, тусламж, төсвийн хөрөнгө оруулалт, Хөгжлийн банкны санхүүжилтээр жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжин ажиллаж байна. Тухайлбал, 2017 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 700 гаруй нарийн ногооны хүлэмжийн аж ахуйг шинээр бий болгож ажилласан бол Хөгжлийн банкны санхүүжилтээр хуурай сүүний үйлдвэрүүдийг санхүүжүүлээд байна. 2018 оны төсөвт 1.98 тэрбум төгрөгийг 800 ширхэг хүлэмжийг 330 суманд барихад суулгасан бол 2018 онд 59 үйлдвэрийн сүүний үйлдвэрийн тоног төхөөрөмжийг суурилуулах ажил хийгдэхээр төлөвлөгдөж байна.</p> <p>-Засгийн газрын үнэт цаасны арилжаанд гадаад дотоодын иргэн, компаниуд зэрэг бусад хөрөнгө оруулагчдын оролцоо оролцоо, өрсөлдөөнийг нэмэгдүүлж, хамрах хүрээг өргөжүүлэн хүүг бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ. Мөн Засгийн газрын өндөр хүүтэй үнэт цаасны гаргалтыг бууруулан санхүү, мөнгөн хөрөнгө, өрийн удирдлагыг оновчтой болгоно.</p> <p>Ингэснээр нь жижиг дунд бизнэс эрхлэгчдэд олгогдох зээлийн эх үүсвэрийн хүү буурах боломж нэмэгдэнэ.</p>
25	Vigo захирал Мандалмаа	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төслийн зээл төрөөс эдгээр бизнес эрхлэгчдийг төрөөс яаж дэмжих вэ?	<p>Жижиг дунд, үйлдвэрлэлийг төрөөс дэмжих хүрээнд дараах ажлуудыг хийнэ.</p> <ul style="list-style-type: none"> • Жилийн орлого нь 1,5 тэрбум төгрөгөөс бага орлоготой аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 1 хувь болгон бууруулах; • Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг зээлийн эрсдэлээс хамгаалах зорилгоор Зээлийн эрсдлийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх; • Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны эрх зүйн орчныг бий болгож тогтолцоог боловсронгуй болгох; • Хөдөө орон нутаг, алслагдсан бүс нутагт бизнес эрхлэлтийг дэмжих "Бүсийн хөнгөлөлтийн" бодлого хэрэгжүүлэх; • Зээлийн батлан даалт болон хөрөнгийн барьцааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох замаар жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх; • ЖДҮ-ийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, нэмүү өртөг шингэсэн худалдаа, үйлдвэр, үйлчилгээ, тээвэр ложистикийн сүлжээг цогцоор нь байгуулж кластерын зарчмаар төлөвлөн хэрэгжүүлэх;

			<ul style="list-style-type: none"> • ЖДҮ-ийн хүний нөөцийг сургах, давтан сургах, үйлдвэр дээрх сургалтыг тогтолцоог хөгжүүлэх; • Шинжлэх ухааны байгууллагуудын бүтээсэн шинэ техник технологийг жижиг, дунд үйлдвэрүүдэд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх; • ЖДҮ-ийг санхүүгийн эх үүсвэрээр дэмжих чиглэлээр төр, хувийн хэвшлийн хамтарсан санхүүжилтийн дэд сан бий болгох, санхүүгийн дэмжлэгийн төрлийг нэмэгдүүлэх; • ЖДҮ эрхлэгчид, өрхийн аж ахуй, бичил бизнес эрхлэгчдэд зориулсан таатай нөхцөл бүхий "Итгэлийн зээл" олгох бодлого баримтална; <p>Бизнесийн орчин дахь төрийн оролцоог багасгаж, төрийн үндэсний үйлдвэрийн худалдан авалтыг нэмэгдүүлэх.</p>
26	Гурванбаян цаст ХХК Цаст солюшн захирал Л. Баатархүү	Инноваци технологийн салбарт төр засгаас ямар бодлого баримтлах гэж байна вэ ?	<p>“Төрөөс инновацийн талаар баримтлах бодлого”-ын төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулахаар Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлээд байгаад. Уг бодлогын төслийн хүрээнд ирэх 10 жилд дараах чиглэлээр бодлогын зорилтуулыг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Үүнд</p> <ol style="list-style-type: none"> 1. Шилдэг мэдлэг, туршлага, эрдэм шинжилгээ, судалгааны үр дүнг үйлдвэрлэл үйлчилгээнд нэвтрүүлж баялаг болгон хувиргах, хувийн хэвшил, нийтийн инновацийн боловсрол, бүтээлч сэтгэлгээг бий болгох, арга механизмыг хөгжүүлэх; 2. Инновацийн үйл ажиллагааг дагнан хэрэгжүүлэх төрийн өмчийн хуулийн этгээд байгуулах, инновацийн бүтээгдэхүүнийг дэмжих зорилго бүхий инновацийн санг байгуулах, инновацийн бүтээгдэхүүний чанарын баталгаажуулалтад олон улсын стандарт нэвтрүүлэх; 3. Инновацийн үйл ажиллагааны санхүүжилтийн механизмд шинэчлэл хийж, олон хэлбэр бүхий санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох, инновацийн үйл ажиллагаанаас олсон орлогоо захиран зарцуулах эрхийг төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагад олгох, инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй аж ахуйн нэгж орлогынхоо нэг хувиас доошгүй хөрөнгийг судалгаа боловсруулалтын ажилд зарцуулсан тохиолдолд төр худалдан авалтаар дэмжих механизмыг хөгжүүлэх 4. Инновацийн боловсрол олгох анхан, дунд, ахисан шатны сургалтын хөтөлбөрүүдэд хамруулах, гадаадад мэргэжил дээшлүүлэх зэргээр мэргэшсэн хүний нөөцийг чадавхжуулах, аж үйлдвэр, инновацийн тэргүүлэх чиглэлээр мэргэшсэн инженер, техникийн ажилтнуудыг үе шаттай, залгамж чанартайгаар бэлтгэх сургалтын тогтолцоог бий болгож, тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх, гадаадад ажиллаж амьдарч буй өндөр мэдлэг чадвартай шилдэг хүний нөөцийг Монголд эргүүлэн авчрах таатай нөхцлийг бий болгон тэднийг баялаг бүтээхэд оролцуулж,

			<p>мэдлэг туршлагаас нь суралцах, инновацийн соёлыг түгээн дэлгэрүүлэх, төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;</p> <p>5. Технологийн инкубатор, туршилтын үйлдвэр, технологи дамжуулах төв, лицензийн товчоо, бизнес-инкубатор, хурдасгуур компани, шинжлэх ухааны паркийг байгуулах, инновацийн тэргүүлэх чиглэлд хамаарах суурь бүтцийг байгуулахад шаардагдах зардлыг төр хариуцах, төрөл бүрийн эх үүсвэртэй санхүүгийн байгууллага, венч сан байгуулахыг төрөөс дэмжих, оюуны өмчийн мэдээлэл, түүнийг ашиглах нэгдсэн тогтолцоог бий болгох, Инновацийн бүтээгдэхүүнийг зах зээлд арилжаалах (commercialization) үндэсний төв байгуулах, орон нутагт инновацийн суурь бүтцийг хөгжүүлэхэд улсын болон орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлэх зохицуулалтыг бий болгох;</p> <p>6. Инновацийн стратегийн тэргүүлэх чиглэлд эрдэс түүхий эд, хөдөө аж ахуйн гаралтай дэвшилтэт технологийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, биологийн гаралтай түүхий эдэд суурилсан өндөр технологийн эко бүтээгдэхүүний үйлдвэрлэл, материалын химийн үйлдвэрлэл гэсэн үндсэн 4 стратегийн чиглэлийг тусган, тухайн чиглэлд улсын хөрөнгө, нөөцийг төвлөрүүлж байх механизмыг бүрдүүлэх зэрэг болно.</p>
27	Гурванбаян цаст ХХК Цаст солюшн захирал Л. Баатархүү	Жижиг дунд үйлдвэрлэл нэрээр оймс, жижиг гар урлал мэт эдийн засагт ч олигтой нөлөөгүй зүйлсийг хэдий болтол дэмжих вэ. Мэдээллийн технологийн салбарт хөнгөлөлттэй зээл, тусламжаар дэмжих боломж хэзээ бий болгох вэ?	БНЭУ-ын 20.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Монгол-Энэтхэгийн хамтарсан мэдээллийн технологийн боловсрол, аутсорсингийн төслийг хэрэгжүүлж байна. Олон улсын түвшинд хүрэхүйц мэргэжлийн өндөр ур чадвартай хүний нөөцийг нэмэгдүүлэх, мэдээллийн технологийн гадаад аутсорсингийг хөгжүүлэх зорилгоор олон улсын жишигт нийцсэн мэдээллийн технологийн боловсрол, аутсорсингийн төвийн барилгыг ШУТИС-ын зүүн талд барьж, тоног төхөөрөмж нийлүүлэх зорилготой юм. Аутсорсингийн үйл ажиллагаа Монгол Улсын гадаад экспортыг багагүй хэмжээгээр нэмэгдүүлэх бөгөөд нийт 25 жилийн хугацаанд 320 орчим сая ам.долларын орлого олох боломжтой гэсэн урьдчилсан тооцоо байна. Олон улсын зах зээлд өөрийн байр суурийг эзэлсэн, өндөр ашиг орлого бүхий цогцолбор төв бий болсноор мэдээллийн технологийн төвлөрөл буюу тусгай бүс бий болох үндэс суурь тавигдаж, салбарын хөгжилд жинтэй хувь нэмэр оруулна. Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар Энэтхэг Улсын Экспорт-Импорт банкнаас урьдчилсан сонгон шалгаруулалт зарласан боловч багц тус бүрд 1 компанийг сонгон шалгаруулж ирүүлсэн байна. БСШУСЯ-наас үнэлгээний хорооны даргыг өөрчлөн нээлттэй тендер зохион байгуулахаар ажиллаж байна.
28	Гурванбаян цаст ХХК Цаст	Ойрын 10 жилд Монгол төр бизнесийн	Монгол Улсын хувьд бодлого төлөвлөлтийг урт, дунд, богино хугацаагаар төлөвлөн хэрэгжүүлж байна. Урт хугацаа буюу 2030 он хүртэлх Хөгжлийн бодлого УИХ-аар батлагдан

	солюшн захирал Л. Баатархүү	ийм салбараа түлхүү дэмжинэ гэсэн бодлого, төлөвлөлт байгаа юу?	хэрэгжиж байна. Таны хэлж байгаа 10 жилийн бодлогын хувьд Төрөөс баримтлах бодлого буюу урт хугацааны бодлогыг хэрэгжүүлэх салбарын бодлого юм. Засгийн газрын хувьд макро эдийн засгийн орчныг сайжруулж, эдийн засгийг тогтворжуулах нь ойрын бодлого боловч цаашид эдийн засгийн дархлааг нэмэгдүүлж, тогтвортой өсөлтийг хангах нь чухал байна. Иймээс одоогоор эдийн засгийн чирэх хүч болоод байгаа уул уурхайн салбарын хөгжлийг дэмжихийн зэрэгцээ уул уурхайн бус салбар буюу аялал жуулчлал, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрлэлийг дэмжиж эдийн засгийг төрөлжүүлэх шаардлагатай байна. Ер нь төр засгийн хувьд эдийн засгийн бүтцийг сайжруулах, экспортыг нэмэгдүүлэх чиглэлийн үйлдвэрлэл үйлчилгээг дэмжиж ажиллана.
29	Nomtush consulting Дэнсмаа	Бага, дунд орлоготой иргэдийг хэрхэн орон сууцжуулах вэ, тэднийг ажлын байраар хангах ойрын болон дунд хугацааны хийхээр төлөвлөж байгаа ажлууд юу байна вэ?	Бага, дунд орлоготой иргэдийг орон сууцжуулах чиглэлээр Засгийн газрын зүгээс ажиллаж байна. Тухайлбал, түрээсийн орон сууцаар хангаж, түрээсэлж байгаа орон сууцаа цаашид өмчлөн авах боломжоор хангах нөхцөлийг бүрдүүлэхээр ажиллаж байна. Түүнчлэн, одоогийн ипотекийн орон сууцны санхүүжилтийн хөтөлбөрийг шинэчлэх ажлын хэсгийг Сангийн яаман дээр гаргаад байгаа бөгөөд энэ хүрээнд урьдчилгаа, хүүгийн хэмжээг бууруулах боломжийг судалж байна. Ойрын хугацаанд судалгааны үр дүн гарч Засгийн газарт танилцуулж, зохих шийдвэрийг гаргуулна. АХБ болон бусад олон улсын байгууллага, донор орнуудын хөнгөлттэй зээлийн санхүүжилтээр гэр хорооллын дахин төлөвлөлтийг үргэлжлүүлж, бага, дунд орлоготой иргэдийг орон сууцжуулах ажлыг эхлүүлэхээр гэрээ, хэлэлцээрийг хийж байна. Гэр хорооллыг орон сууцжуулах гэхээр тулгардаг хамгийн том бэрхшээл нь дэд бүтэц, инженерийн шугамын асуудал байдаг. Тиймд захын гэр хорооллуудад орон сууцны бичил төвүүдийг байгуулахаар ажиллаж байна. 200 айлын дунд цэвэр бохир ус, халаалтын бүх асуудлыг шийдсэн төвтэй болно. Энэ ажлыг БНХАУ-ын хоёр тэрбум төгрөгийн буцалтгүй тусламжаар хийхээр төлөвлөж байна.
30	Өнөрхаус ХХК Ж.Мэндбаяр	Дагуул хот байгуулах саналаа танилцуулна	Засгийн газрын зүгээс Хөшгийн хөндийд дагуул хот байгуулах, Багануур хотод Их, дээд сургуулийн хотхон байдлаар дагуул хот байгуулах ажлуудыг хийхээр төлөвлөн ажиллаж байна. Тухайлбал, Хөшгийн хөндийд дагуул хот байгуулах ерөнхий төлөвлөгөөний тодотголыг хийж байгаа бол Их, дээд сургуулиудын хотхон байгуулах ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ зэрэг судалгаанууд бүрэн хийгдээд байна.
31	Twinhouse construction Ням-Очир	Барилга угсралтын компаниудад тэр дундаа өөрсдийн хөрөнгө оруулалтаар үйл ажиллагаагаа явуулж, ЗГ-ын гэр хорооллын дахин төлөвлөлтийг дэмжин	Сангийн яам нь тус асуудалтай холбоотой санал, гомдол ирж байгааг мэдэж байгаа. Монголбанкнаас иргэдийг орон сууцжуулах ипотекийн зээлийн журмыг баталж гаргадаг ба арилжааны банкууд тус журмыг ипотекийн зээлийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг. Манайхаас уг асуудлыг хүрээнд Монголбанкинд албан тоот хүргүүлсэн байгаа.

		ажиллаж буй байгууллагуудад ипотекийн 8% зээл олгогдохгүй байгаа хараат байдал хэр удаан үргэлжлэх вэ? Ямар арга зах гарц байгаа вэ?	
32	Гербридж ХХК Гэрэлт-Од	Барилгын салбарт тулгарч байгаа бизнесийн орчин болон татварын орчинг яаж сайжруулах вэ?	Хөрөнгө оруулалтын тухай хуулиар барилгын салбарт үйл ажиллагаа явуулах бизнес эрхлэгчид тогтворжуулах гэрчилгээ олгох, хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах боломжийг олгодог. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийн худалдан авсан үндсэн хөрөнгөд төлсөн НӨАТ-ийг хасахгүй гэснийг өөрчилж, ААНОАТ-ын тухай хуульд заасан зарчмаар хасагдуулахаар холбогдох хуулийн төслийг боловсруулаад байна.
33	ЕСС LLC Мандахбаяр	Дагуул хот, Майдар төслийг дэмжиж төрөөс хөрөнгө оруулах уу?	Засгийн газрын зүгээс дагуул хот барихыг дэмжиж байгаа. Тухайлбал, Хөшгийн хөндийд дагуул хот байгуулах, Багануур хотод Их, дээд сургуулийн хотхон байдлаар дагуул хот байгуулах ажлуудыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.
34	ЕСС LLC Мандахбаяр	Гэр хорооллын дахин төлөвлөлт дээр хөрөнгө босгох тохиолдолд ЗГ-ын баталгаа гаргаж өгөх үү?	Засгийн газрын баталгаа гаргах тухайн төсөл хөтөлбөр нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцэж, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан байх, тухайн төсөл арга хэмжээний төрлөөс хамааран зураг, төсөв техник эдийн засгийн үндэслэл, нийгмийн болон байгаль орчны нөлөөллийн шинжилгээ хийж, баталгаажуулсан байх зэрэг шаардлагуудыг хангасан байх тухай энэхүү хуульд заасан. Түүнчлэн, тухайн төсөл хөтөлбөрийн төлбөрийн чадварт эрсдэлийн үнэлгээ хийж, гаргасан санал дүгнэлтийг үндэслэн Засгийн газрын баталгаа гаргах боломжтой эсэхийг шийдвэрлэдэг, хуулиар зохицуулагддаг асуудал юм.
35	Чингис хаан банк Даваажав	Засгийн газар 2018-2020 оны хооронд барилгын салбарт ямар бодлого барьж ажиллахаар байгаа вэ? Ипотекийн зээлийг төр хэзээнээс	Шинээр хэрэгжих ипотекийн зээлийн тогтолцооны хүрээнд төсвөөс 2018 онд 120.0 тэрбум төгрөг, МБ-ны өөрийн эх үүсвэрээр олгосон ипотекийн орон сууцны хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлтөөс 220.0 тэрбум төгрөгийн эх үүсвэр төсөвлөөд байна.

		дэмжиж, эрчимжүүлж эхлэх вэ?	
36	Геологийн төв лаборатори Э.Тэгшжаргал	Нэг өрхийн 2 гишүүн хоёулаа ажил хийж нийгмийн даатгал төлдөг бол байранд урьдчилгаагүй оруулж өгөх	Ипотекийн зээлийн шалгуурыг заавал хангасан байх ёстой бөгөөд журамд заасны дагуу урьдчилгаа төлбөр төлж байж орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамрагдана.
37	Ganabell institute Гандолгор	Гадагшаа ажиллах хүч алдаж байгаа нь эргээд байгууллага, улмаар улс орны хувьд ажиллах хүчний хомсдолд оруулах аюул нүүрлээд байна. Хүн хэмээх менежментийн нөөцийг зөв удирдах ямар бодлого, хөтөлбөр явуулах вэ.	Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 онд үйл ажиллагааны хөтөлбөрт бид энэ чиглэлээр томоохон зорилтууд тавьсан байгаа. Тухайлбал, “3.3.1. Монгол хүний үнэ цэнэ, үнэлэмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх бодлогыг бүх салбарт баримтлах”-аар тусгасан байгаа. Мөн бид “3.3.6. Монгол залуусаа сургаж дадлагажуулан ажлын байраар хангаж, гадаадаас авдаг ажиллагчдын тоог 50-аас дээш хувиар бууруулах” томоохон бодлогыг тусгасан. Энэ бодлогын хүрээнд гадаадаас ажиллах хүч авахад тавигдах шаардлагыг дотоодын ажиллах хүчний нөөц бололцоо, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн боловсронгуй болгож, нарийвчлан тогтооно. Мөн дотоодын ажиллах хүчийг гадаадын өндөр ур чадвартай мэргэжилтнийг дагалдуулан сургаж, ажлын байраар хангах юм. Харин гадаадад хөдөлмөрийн гэрээгээр болон дадлагажигчийн хөтөлбөрийн хүрээнд ажиллах Монгол иргэдийг хөдөлмөрийн бүтээмж, үнэлэмж өндөртэй, стратегийн ач холбогдол бүхий салбарт ажиллах боломжийг бүрдүүлнэ. Мөн Монгол Улсын иргэн гадаадад, гадаадын иргэн Монгол Улсад хөдөлмөр эрхлэх, тэдний эрхийг хамгаалах эрх зүйн орчинг бүрдүүлэх болно.
38	Тост нөхөрлөл ахлагч Сүрэнхүү	Газар тариалан, хүнсний ногоо тариалан эрхлэгчдийг дэмжсэн бодлого явуулах уу?	Газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг хувь хүн, хуулийн этгээд өөрөө бэлтгэсэн буюу тариалсан, үйлдвэрлэлийн анхан шатны боловсруулалтад ороогүй төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ болон дотооддоо үйлдвэрлэсэн гурилыг дотоодын үйлдвэрлэгчдэд борлуулсан бол үнийн дүнд нь 10 хувийн НӨАТ шингэсэн гэж үзэж, тэдгээрийг худалдан авсан албан татвар суутган төлөгчийн НӨАТ-ыг уг хувиар хасаж тооцохыг зөвшөөрсөн байдаг. Тэдгээрийн үйлдвэрлэсэн эцсийн бүтээгдэхүүнийг хилийн чанадад экспортлоход НӨАТ-ын 0 хувь ногдуулдаг. Түүнчлэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийн худалдан авсан үндсэн хөрөнгөд төлсөн НӨАТ-ийг хасахгүй гэснийг өөрчилж, ААНОАТ-ын тухай хуульд заасан зарчмаар хасагдуулахаар холбогдох хуулийн төслийг боловсруулаад байна.
39	Алтан Оршихуй Корпораци Б.Билгүүдэй	Газрын тосны салбарт ямар байр суурь ямар байр суурь баримталж байна. Энэ салбарт	Газрын тосны салбарт Энэтхэгийн 1 тэрбум.ам.долларын хөнгөлөлттэй зээлээр 2018 онд "Газрын тос боловсруулах үйлдвэрийн барих" ажлын нарийвчилсан ТЭЗҮ-ийг хүлээн авч, үйлдвэрийн барилгын ажлыг эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

		хувийн хэвшлийн дэмжиж ажиллах уу?	
40	Эс Би Эйч Би гүйцэтгэх захирал Х.Эрдэнэбулган	Газрын тосны эрэл хайгуулын ажил явуулахад орон нутаг хүчтэй эсэргүүцдэг, энэ тал дээр ямар арга хэмжээ авах вэ?	Газрын тосны хайгуул болон ашиглалтын үйл ажиллагаанд төр болон нутгийн удирдлагын байгууллагуудын уялдааг сайжруулж, газрын тостой холбогдсон үйл ажиллагааг нутгийн ард иргэдэд танилцуулж, хамтран ажиллана. Мөн газрын тосны үйл ажиллагаатай холбоотойгоор байгаль орчинд учирсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авч ажиллана.
41	БОЖСС Косметик ХХК Ж.Батсүх	Гоо сайхны үйлдвэрлэл, худалдаа өргөжиж байгаатай холбогдуулан салбар болгон хөгжүүлэх.	Гоо сайхны бүтээгдэхүүн нь хүмүүсийн эрүүл мэндийн асуудалтай салшгүй холбоотой учраас гоо сайхны үйлдвэрлэл эрхлэгчид чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь чухал юм. Монгол Улсын хувьд сүүлийн жилүүдэд гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэл дэлхийн жишгийг даган өндөр түвшинд хөгжиж байна. Бүтээгдэхүүний орц найрлагад орох боломжтой түүхий эд /малын гаралтай, ургамлын гаралтай гэх мэт/ манай оронд элбэг байдаг нь цаашид үйлдвэрлэл өргөжин тэлэх боломжтойг илтгэж байна. Аль ч салбарын хувьд дотоодын үйлдвэрлэл нэмэгдэх нь Монгол Улсын эдийн засагт чухал хувь нэмэр оруулж байдаг. Гагцхүү цаашид өргөжин тэлэх эсэх нь тухайн бүтээгдэхүүний чанартай шууд холбоотой юм.
42	БОЖСС Косметик ХХК Ж.Батсүх	Гоо сайхны стандартыг дэлхийн жишигт шинэчлэн боловсруулах.	Үндэсний үйлдвэрлэгчид Монгол улсад хэрэгжиж буй стандартыг юун түрүүнд мөрдөж ажиллах нь чухал байна. Цаашид олон улсын стандартыг нутагшуулах чиглэлээр ажиллах нь зүйтэй. Олон улсын стандартын шаардлагыг хангаж үйл ажиллагаагаа явуулж байгаа үйлдвэрүүд Монголд олон байгаа, тиймээс стандартыг дэлхийн жишигт шинэчлэн боловсруулах ажлыг хэрэглэгчдийн итгэлийг даасан үйлдвэрлэгчидтэй хамтран хэрэгжүүлэх нь үр дүнтэй юм.
43	Амин ногоон ус ХХК Баясгалан	Үндэсний үйлдвэрлэгч байгууллага нарт хөнгөлөлттэй зээлийн бодлого байгаа эсэх?	Экспортын шугам нээх төсөл /Япон/ 8 сая иен, Япон Улсын орчин үеийн техник технологи, тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх замаар үндэсний үйлдвэрлэл, хувийн хэвшлийг дэмжих зорилго бүхий энэхүү төслийн хүрээнд зээлийн хөрөнгийг төсөлд оролцогч Монгол Улсын арилжааны 7-н банкаар дамжуулан дотоодын аж ахуйн нэгж байгууллагуудад дамжуулан зээлдүүлнэ. JICA-ийн 2 үе шаттай зээлийн хүрээнд 780 ААН-д 262,9 тэрбум төгрөгийн зээл олгооод байна. АХБ-ны Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт төслийн хүрээнд 2017.12.31-ний өдрийн байдлаар нийтдээ 17 зээл АХБ болон ТУХ-оор батлагдсан. Нийт 40.1 тэрбум ₮-ийн гэрээ байгуулагдаж, 35.2 тэрбум ₮-ийн санхүүжилт хийсэн.
44	Алтанбулаг чөлөөт бүс албаны дарга Балжмаа	ААН-ын барааны дэлгүүрийг өдөр бүр өглөө оройдоо лацаддаг. Лацны	Алтанбулаг чөлөөт бүс дэх бүх үйл ажиллагаа Чөлөөт бүсийн тухай хуулиар явах ёстой.

		үнийг ААН-үүдээр гаргуулдаг.	
45	Бум констракшн Х.Буман	Эрдэнэт-Овоот төмөр замын төсөлд үндэсний компаниудаас оролцуулах уу?	<p>Монгол улсын нутаг дэвсгэр дэх Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замыг барих төсөлд Австралийн хөрөнгийн биржид бүртгэлтэй “Aspire Mining” болон охин компани “Northern Railways” нь Хятадын “China Gezhouba Group International” (CGGC) компанитай хамтран ажиллах санамж бичгийг байгуулсан бөгөөд төмөр замыг барьж, ашиглалтад оруулах 30 жилийн концессын гэрээг Монгол Улсын Засгийн газартай 2015 онд байгуулсан.</p> <p>2017.06.20-ны өдөр Эрдэнэт хотод төмөр замын барилгын ажлын нээлтийг хийж шав тавих ёслолыг хийсэн. Концесс эзэмшигч тус төмөр замын төслийн ТЭЗҮ(Bankable Feasibility Study)-ийн төгсгөлийн шатны тайланг боловсруулах ажлыг санхүүжүүлж гүйцэтгэх, цаашид хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичгийг БНХАУ-ын “Чайна гэжуба групп” корпорацитай байгуулж, ТЭЗҮ-ийн төгсгөлийн шатны тайланг эцэслэн боловсруулж байна. Олон улсын банк санхүүгийн байгууллагын шаардлага хангасан ТЭЗҮ (Bankable Feasibility Study)-ийг 2018 оны эхний улиралд багтаан боловсруулж дуусган төмөр замын барилгын ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна.</p>
46	ЭС АР БИ ХХК, Мөнгөнчимэг,	Улсаас Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих ямар үйл ажиллагаа хийж байгаа вэ	<p>Засгийн газраас Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр дараахь ажлыг хэрэгжүүлж байна.</p> <ol style="list-style-type: none"> 1. Төсвийн алдагдлын түвшинг бууруулж, Засгийн газрын дотоодоос зээлэх зээллэгийн хэмжээг бууруулж, хувийн хэвшилд олгох зээл болон хөрөнгө оруулалтыг бууруулах бодлогыг баримталж байна. Энэ нь арилжааны банкны хүүг бууруулахад нөлөөлөх болно. 2. Монгол Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулж, гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээх замаар Засгийн газрын гадаад бондны хүүг бууруулах ажлыг хийж байна. Ингэснээр Үндэсний үйлдвэрүүдийн гадаад зах зээлээс хөрөнгө татах хүүгийн хэмжээ дагаад буурах бололцоотой. 3. Төсвийн хөрөнгөөр Дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг худалдан авах бодлогыг баримталж байна. 4. Засгийн газрын баталгаатай босгосон Хөгжлийн банкны санхүүгийн эх үүсвэрийн тодорхой хэсэг болон Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр эдийн засаг, нийгмийн үр ашиг өндөртэй төслүүдэд олгож, дэмжиж байна. 5. Зээлийн батлан сангаар дамжуулан барьцаа хөрөнгийн дутагдалтай Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд батлан даалт гарган дэмжиж байна. 6. Татварын жилийн албан татвар ногдох орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй, газар тариалан, мал аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, нэхмэл, хувцасны үйлдвэрлэл, барилгын материалын үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжийн албан татварыг 90 хувиар хөнгөлнө.

47	Монос Фарм ХХК, Цогт-Очир	Үндэсний үйлдвэрлэлийг Засгийн газрын зүгээс дэмжих бодлого юу вэ?	<p>Засгийн газраас Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр дараахь ажлыг хэрэгжүүлж байна.</p> <ol style="list-style-type: none"> 1. Төсвийн алдагдлын түвшинг бууруулж, Засгийн газрын дотоодоос зээлэх зээллэгийн хэмжээг бууруулж, хувийн хэвшилд олгох зээл болон хөрөнгө оруулалтыг бууруулах бодлогыг баримталж байна. Энэ нь арилжааны банкны хүүг бууруулахад нөлөөлөх болно. 2. Монгол Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулж, гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээх замаар Засгийн газрын гадаад бондны хүүг бууруулах ажлыг хийж байна. Ингэснээр Үндэсний үйлдвэрүүдийн гадаад зах зээлээс хөрөнгө татах хүүгийн хэмжээ дагаад буурах бололцоотой. 3. Төсвийн хөрөнгөөр Дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг худалдан авах бодлогыг баримталж байна. 4. Засгийн газрын баталгаатай босгосон Хөгжлийн банкны санхүүгийн эх үүсвэрийн тодорхой хэсэг болон Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр эдийн засаг, нийгмийн үр ашиг өндөртэй төслүүдэд олгож, дэмжиж байна. 5. Зээлийн батлан сангаар дамжуулан барьцаа хөрөнгийн дутагдалтай Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд батлан даалт гарган дэмжиж байна. 6. Татварын жилийн албан татвар ногдох орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй, газар тариалан, мал аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, нэхмэл, хувцасны үйлдвэрлэл, барилгын материалын үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжийн албан татварыг 90 хувиар хөнгөлнө.
48	Уушгийн агуй С.Гансүх	ОХУ болон БНХАУ руу мал аж ахуйн гаралтай эцсийн бүтээгдэхүүнүүдийг экспортлоход хоёр улсын худалдааны төр засгийн байгууллага, хил гаалийн хөнгөлөлтийг хүссэн уулзалт зохион байгуулах боломжтой эсэхийг тодруулах ажлын хэсгийг МУ-ын холбогдох төр засгийн удирдагч	<p>ОХУ болон БНХАУ-тай Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны асуудал хэлэлцэж, шийдвэрлэх Засгийн газар хоорондын уулзалтыг тогтмол хийж байна. Энэхүү уулзалтаар мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний (мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, ноос, ноолуур, арьс шир, нэхий эдлэл) хил гаалийн хөнгөлөлт, тарифын болон тарифын бус хоригийг багасгах асуудлыг хамтарч шийдэхээр тохиролцоонд хүрэн, хэрхэн шийдэх талаар судалж байна.</p> <p>Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын Монголын хэсгийн даргаар Гадаад харилцааны сайд, орлогч даргаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд ажиллаж байна.</p> <p>Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол-Хятадын Засгийн газар хоорондын комиссын Монголын хэсгийн даргаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, орлогч даргаар Зам, тээврийн хөгжлийн сайд ажиллаж байна.</p> <p>Мөн “Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 27 дугаар тогтоолоор “Гаалийн тарифын зөвлөлийн</p>

		байгууллагуудыг тодорхой болгох хүсэлтэй байна. /1. Мах, махан бүтээгдэхүүн, 2. Сүү, сүүн бүтээгдэхүүн, 3. Ноос, ноолуур, хөөврөн бүтээгдэхүүн, 4. Арьс, арьс ширэн бүтээгдэхүүн/	бүрэлдэхүүн” болон “Дэлхийн худалдааны байгууллагын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий Үндэсний хороо” зэргийг байгуулан ажиллуулж байна. Гаалийн тарифын зөвлөлийн бүрэлдэхүүний даргаар Сангийн сайд, орлогч даргаар Гадаад харилцааны дэд сайд ажиллаж байна. Дэлхийн худалдааны байгууллагын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий үндэсний хороог Гадаад харилцааны сайд даргалж байна.
49	Ангара дэвших трейд ХХК Алтанбулаг чөлөөт бүс Ц.Туяа Балжмаа	Чөлөөт бүсийн тухай хуулийн 3.0 сая төгрөгийн барааг татваргүй гарга гэсэн заалт хэрэгжихгүй байна.	Чөлөөт бүсийн тухай хуулиар зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлээс гадна зорчигчийн худалдан авсан 3.0 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй барааг чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад гаалийн хялбарчилсан бүрдүүлэлт хийдэг болно.
50	Ангара дэвших трейд ХХК Алтанбулаг чөлөөт бүс Ц.Туяа Балжмаа	Гаалийн ажилтнууд чөлөөт бүсийн ААН-үүдтэй ёс зүйгүй харьцдаг, байцаагч нар нь өөрсдөө авч гарах барааны хэмжээг тогтоодог. Үйлчлүүлэгчид буруу мэдээлэл өгдөг. ЗГ мөрийн хөтөлбөрт “Чөлөөт бүсүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжиж ажиллана” гэсэн Засгийн газрын бодлогын эсрэг ярьдаг. Чөлөөт бүсийг	БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 58.8 сая ам.долларын өртөг бүхий “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл”-ийг 2011-2018 онд хэрэгжүүлж байна. “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүс, Замын-Үүд сумыг ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу инженерийн дэд бүтцээр бүрэн хангаж, орчин үеийн шаардлагыг хангасан Чөлөөт бүс бүхий хот суурин газрыг бий болгох зорилготой юм. Орчин үеийн шаардлагыг хангасан эдийн засгийн чөлөөт бүс бүхий хот суурин газрыг бий болгон “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийг 2029 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн зэрэгцээ тухайн сумын хүн ам, оршин суугчдыг аюулгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан тохилог орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх нийгэм эдийн засгийн үр ашигтай байна. Мөн, Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 45 сая ам.долларын өртөг бүхий “Бүс нутгийн ложистикийн төвийг хөгжүүлэх төсөл”-ийг 2011-2018 онд хэрэгжүүлж байна. Мянганы хөгжлийн зорилтуудыг хангах таатай нөхцөл бүрдүүлэх, гадаадаас Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тээвэрлэлтийг нэмэгдүүлж үр ашгийг дээшлүүлэхэд оршино. Замын-Үүд боомтод үр ашигтай, өрсөлдөхүйц, найдвартай холимог тээврийн системийг хөгжүүлэх, ложистикийн төвийг байгуулах зорилготой. Тус ложистикийн төв нь 24 цагийн үйл ажиллагаатай байх ба 2 ээлжээр ажиллах бөгөөд хоногт 600 орчим вагон буюу 12 галт тэрэг БНХАУ-ын талаас хүлээн авч ачиж буулгах, шилжүүлэн ачилт хийх хүчин чадалтай байхаар урьдчилсан байдлаар тооцоологдсон болно. Төслийн гүйцэтгэгч компани 2017 оны барилга угсралтын ажилд шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг Монгол Улсын

		ад шоо үздэг. Арга хэмжээ авч өгнө үү?	хилээр оруулж ирэн барилга угсралтын ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт ажлын гүйцэтгэл 75.2% байна. Түүнчлэн, Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 27 сая ам.долларын өртөг бүхий “Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл”-ийг 2017-2021 онд хэрэгжүүлж байна. Тус төслийн зорилго нь хилийн үйлчилгээг сайжруулах замаар гадаад худалдааг илүү шуурхай, боловсронгуй болгох, бараа эргэлтийг нэмэгдүүлэхэд түлхэц үзүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, худалдаа эрхлэхэд зарцуулж буй зардал бууруулах, цаг хугацаа хэмнэхэд оршино. Төслийн хүрээнд нийт 3 боомт буюу Алтанбулаг, Бичигт болон Замын-Үүд-ийн боомтуудын барилга байгууламж ба тоног төхөөрөмжийг шинэчлэх, сайжруулах, гаалийн автоматжуулсан мэдээллийн систем /КАИС/-ийг сайжруулах, сүлжээний дэд бүтцийг өргөтгөх, тоног төхөөрөмжийг шинэчлэх болон цахим нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах зэрэг ажлууд хийгдэх юм. Тус төслийг хэрэгжүүлснээр худалдаа эрхлэх ажиллагаа хялбар, ойлгомжтой болох, шаардлагатай зөвшөөрөл, лицензийг олон шат дараалалгүйгээр нэг хандалтаар, нэг дороос авах боломж бий болох, гадаад худалдаа эрхлэхэд зарцуулах зардал ба цаг хугацаа багасах, гадаад худалдааны эргэлт нэмэгдэж, өрсөлдөх чадвар сайжрах, дамжин өнгөрөх тээврийн хэмжээ нэмэгдэх, олон улсын байгууллагуудаас гаргадаг тайлангуудад Монгол Улсын эзлэх байр, суурь нэмэгдэх, хилийн боомтууд дээр урт дараалал үүсэхгүй болох, гааль, татварын мэдээллийн систем харилцан уялдаатай ажилладаг болсоноор бодит мэдээллийг хугацаа алдалгүй авах боломж бүрдэнэ. Нэгдсэн мэдээллийн системтэй болох бөгөөд төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо сайжирна.
51	Алтанбулаг чөлөөт бүс Балжмаа	Чөлөөт бүс руу импортолж оруулж ирсэн барааг дахин импорт гэж үздэг. Нэгэнт импортлоод ирсэн барааг худалдаж авахад дахин импорт гэж үзэхгүй байх хэрэгтэй.	Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1-т “хилийн чанадаас гаалийн баталгаат бүс, татваргүй барааны дэлгүүр, гаалийн тусгай бүс, чөлөөт бүсэд шууд оруулах болон тэндээс хилийн чанадад шууд гаргах бараа” заасны дагуу чөлөөт бүсэд оруулсан барааг хилийн чанадад гаргахад гаалийн болон бусад татварыг ногдуулдаггүй болно.
52	ACCL Mongolia захирал Саран	Гашуун Сухайт боомт дээр хийгдсэн зохицуулалтын талаар юу гэж бодож байгаа вэ?	Монгол Улсын хилийн боомтуудад одоогийн байдлаар төрийн болон бусад ажилтан албан хаагчид, иргэдийн ажиллаж амьдрах таатай, эрүүл, аюулгүй орчин, нийгэм, эдийн засгийн нөхцөл хангалттай бүрдээгүй байна. Иймээс Монгол Улсын хилийн боомтуудыг дэд бүтэцтэй, ажиллаж амьдрах таатай орчин бүхий олон улсын жишигт нийцэхүйц суурин газар болгон хөгжүүлэхийн зэрэгцээ хилийн боомтын шалган нэвтрүүлэх орц, гарцуудын

			<p>төлөвлөлтийг МУ-ын эдийн засгийг дэмжсэн хамгийн оновчтой шийдлээр төлөвлөн, барьж байгуулах зайлшгүй шаардлага тулгараад байна.</p> <p>Уг тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэхээр Монгол Улсын Засгийн 2016 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 196 дугаар тогтоолоор “Хөгжлийн хөтөч-дэд бүтэц” төслийн нэгжийг Сангийн яамны дэргэд байгуулсан билээ. Тус төслийн нэгж нь Хилийн боомт дэд төслийг хэрэгжүүлж байна.</p> <p>Мөн Монгол Улсын Засгийн газарт БНХАУ-ын Засгийн газраас олгож буй буцалтгүй тусламжийн хөрөнгөөр эхний ээлжид Замын-Үүд, Гашуунсухайт хилийн боомтуудыг хөгжүүлэх төслийн саналыг хүргүүлээд байна.</p>
53	Лансын хишиг ХХК Оюун-Эрдэнэ	Махны экспортын талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар санаа бодлоо солилцох хүсэлтэй байна.	<p>Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Мах, сүүний анхдугаар аян зохионо” гэж тусгасан. Энэ дагуу 2017 оны нэгдүгээр сарын 1-нээс “Мах, сүүний анхдугаар аян”-ыг улсын хэмжээнд өрнүүлж байна. Аянд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөв болон хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулах замаар шийдвэрлэж байна. Энэ хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> • “Мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих дэд хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж байна. • ОХУ-ын Засгийн газрын дэмжлэгтэйгээр мал эрүүлжүүлэх хоёрдахь шатны төслийг хэрэгжүүлэхээр болов. • Монгол Улсаас Иран улс руу хонины мах экспортолж эхэлсэн. • ОХУ болон БНХАУ-тай мах, махан бүтээгдэхүүн нийлүүлэх, хил гаалийн хорио цээрийг хөнгөвчлөх санамж бичиг, хэлэлцээрүүдийг амжилттай хийж байна. <p>Дээрх арга хэмжээний үр дүнд 2017 оны эцсийн байдлаар нийт 29.3 мян.тн мах, 2.8 мян.тн лаазалсан махан бүтээгдэхүүн экспортлоод байна. Өнгөрсөн жилтэй харьцуулахад махны экспорт 3 дахин, лаазалсан махан бүтээгдэхүүний экспорт 6.5 дахин өсөөд байна.</p>
54	Улаанбаатар Ариутгал ХХК Отгонжаргал	Хөрсний бохирдол, гэр хорооллын айлуудын нүхэн жорлонг сайжруулах чиглэлээр ямар ажлууд энэ хавар хийгдэх вэ?	<p>Орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн, бодитой үйл ажиллагааг тодорхойлсон нэгдсэн бодлого боловсруулж, техник, технологи, хөрөнгө санхүү, хүний нөөцийн бүхий л боломжийг ашиглан салбар дундын нэгдсэн зохицуулалтаар хангана. Монгол Улсын Засгийн газраас агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах хөтөлбөр гаргасан. Энэ хөтөлбөрийн хүрээнд үе шаттай тодорхой арга хэмжээг авч байна. БОАЖЯ зүгээс гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг боловсронгуй болгох хөрсний бохирдлыг бууруулах төсөл хэрэгжүүлж байгаа. Японы буцалтгүй тусламжаар нийслэлийн гэр хорооллын хөрсний бохирдлыг бууруулах төсөл хэрэгжиж байгаа. Төслийн хүрээнд 1500 орчим айл өрхийн ариун цэврийн байгууламжийг шинэчлэх бөгөөд 30 хувь өрх толгойлсон эмэгтэйчүүдийг хамруулах байгаа.</p>

55	Феникс констракшн	Утаа орчны бохирдлын талаар авч хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа шийдлүүдийн талаар?	<p>Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор батлагдсан “Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр” батлагдаж, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд: Цахилгааны 2 тарифт тоолууртай нийслэлийн болон төвийн бүсийн системд холбогдсон гэр хорооллын айл өрхийн шөнийн цахилгааныг 100% (сарын хөнгөлөлтийн хязгаар 700 кВтц), бусад аймаг орон нутгийн гэр хорооллын айл өрхийн шөнийн цахилгааныг 50% халаалтын улирал буюу 11-3 саруудад хөнгөлөлт үйлчилсэн бөгөөд 2017 онд гэр хорооллын 114512 хэрэглэгчдэд 3,363 сая төгрөгийн цахилгааны хөнгөлөлт үзүүлсэн байна. Хөнгөлөлтийн хугацаанд шөнийн хамгийн их ачаалал 405МВт-д хүрсэн нь өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад шөнийн ачаалал 70 МВт-аар буюу 17% өссөн. Шөнийн тарифыг тэглэснээр (гэр хорооллын нэг айл өрхийн цахилгаан халаагуурын чадлыг дунджаар 4кВт-аар тооцвол) нийт хөнгөлөлт үзүүлсэн айл өрхийн 17,500 буюу 15,2% нь цахилгаан халаагуур ашигласаныг дүгнэв.</p> <p>Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2016 оны 12-р сарын 02 дугаар тогтоолд “Зорилтот бүлэгт сайжруулсан зуух, боловсруулсан түлшийг олгох”-оор шийдвэрлэж, арга хэмжээг зохион байгуулахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар зохион байгуулсан. Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын зорилтот бүлгийн 1600 өрхийг боловсруулсан түлшээр, 390 өрхийг цахилгаан халаагуураар хангах ажлыг зохион байгуулж, тус арга хэмжээнд улсын болон нийслэлийн төсвийн хөрөнгөөр нийт 1350.0 сая төгрөг зарцуулсан байна.</p> <p>Нийтдээ урьдчилсан байдлаар 4,5 тэрбум төгрөгийг улсын төсвөөс зарцуулсан байна.</p> <p>Шийдлүүд: Богино хугацаанд 1-2 жил</p> <ol style="list-style-type: none"> 1. “Хямд өртөгтэй орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд амины орон сууцыг хөгжүүлэхэд чиглэсэн дэд бүтцийг гэр хороололд байгуулж, орон сууцжуулах ажлыг эрчимжүүлэн залуус, бага, дунд орлоготой иргэдийг урт хугацаатай, бага хүүтэй зээлд хамруулах, ажлын байраар хангах, эхний ээлжинд гэр хороололын иргэдийг орон сууцны зээлд хамруулах, 2. Улаанбаатар хотод ажиллаж байгаа халаалтын зуухыг буулган хэрэглэгчийг төвлөрсөн болон хэсэгчилсэн инженерийн хангамжид үе шаттайгаар холбох, 3. Их, дээд сургуулиуд, цэргийн ангиудыг нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах үе шаттайгаар хотоос гаргах, оюутны хотхоныг бий болгох, 4. Ипотекийн нөхцлийг хөнгөвчлөх, дунд орлоготой иргэдэд зориулж, зээлийн нөхцлийг уян хатан болгох, /Төрийн үйлчилгээний ажилтнууд/цагдаа , эмч, багш нар/-ыг цалингаар нь барьцаалж 8 хувийн зээлд хамруулах,/ 5. “Гэр хороололын газрыг орон сууцаар солих,

6. Да хүрээ, 100 айлын барилгын материалын захиудыг яаралтай хотоос гаргах,
7. Дизель түлшний хэрэглээг хориглох,
8. Эрчим хүчний хүчин чадлыг нэмэгдүүлэх, өргөжүүлэх, төвлөрсөн дулаан хангамжинд холбох,
9. Дугуй засварын /жижиг/ ТҮЦ газруудыг яаралтай хаалгах, нэгдсэн сервис үйлчилгээнд шилжүүлэх,

Дунд хугацаанд 3-5 жил

10. Гэр хороололын дахин төлөвлөлтийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд гэр хороололын инженерийн дэд бүтэц, сервис центрийн ажлыг эрчимжүүлэх,
11. Хөрөнгө оруулалтыг орон нутаг руу чиглүүлж, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлж ажлын байр бий болгох, хөдөөгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, хөдөө орон нутаг руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг дэмжих,
12. Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих, татварын бодлогоор дэмжих, ЖДҮ хөгжүүлэх,
13. Орон нутагт МСҮТ хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх,

Урт хугацаанд 5-10 жил

14. Хөдөө аж ахуйн салбар, хүнсний ногооны өртгийн сүлжээг хөгжүүлэх, хөдөө аж ахуйн биржийг хөгжүүлэх /арьс шир, ноос, ноолуур, мах, сүү/ажлын байр бий болгох, хөдөөг хөгжүүлэхэд онцгой анхаарах,
15. Бүсийн нэмэгдлийг судалж, хөдөө, орон нутагт ажиллаж байгаа Төрийн албан хаагчдын цалинг үе шаттайгаар нэмэгдүүлэх, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх,
16. Хотын татварыг нэмэгдүүлэх, шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, хотын төвийн автомашины зогсоолын төлбөрийг нэмэгдүүлэх,
17. Бүсчилсэн хөгжлийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх, бүсийн тулгуур төв, аймгийн төвүүдийг хөгжүүлэх, хямд үнэтэй орон сууцны зээлд хамруулах, түрээсийн орон сууцыг хөгжүүлэх,
18. Бүсийн нэмэгдлийг судалж, хөдөө, орон нутагт ажиллаж байгаа Төрийн албан хаагчдын цалинг үе шаттайгаар нэмэгдүүлэх, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх,
19. Ажилгүй иргэдийн судалгааг гаргаж хөдөө орон нутагт шилжин амьдрахад нь дэмжлэг үзүүлж / 30-40 бог мал өгөх/
20. Тээврийн хэрэгслийг үнэгүй болгох,

			<p>21. Түрээсийн орон сууцыг яаралтай барьж, амьжиргааны доод түвшний өрхүүдийг эхний ээлжинд түрээсийн орон сууцанд оруулах, орлого багатай хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настнуудыг хамруулах,</p> <p>22. Ногоон байгууламж, хөв цөөрмийн тоог нэмэгдүүлэх, хиймэл нуур, усан сан байгуулах ажлыг бодлогоор дэмжих, гэр хорооллын айлуудын нүүсэн сул газрыг ногоон байгууламж болгон арчлах, хамгаалах ажлыг зохион байгуулах ажлуудыг үе шаттай хэрэгжүүлэх,</p> <p>Иймд агаар, орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн, бодитой үйл ажиллагааг тодорхойлсон нэгдсэн бодлого боловсруулж, техник, технологи, хөрөнгө санхүү, хүний нөөцийн бүхий л боломжийг ашиглан салбар дундын нэгдсэн зохицуулалтыг ханган хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.</p>
56	Хүрээ Сити ХХК	Агаарын бохирдлыг бууруулах тухай ямар ямар арга хэмжээ авч байгааг болон ямар үр дүнд хүрнэ гэж тооцож байгаа вэ?	“Агаарын бохирдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хууль, Агаарын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиудад УИХ-ын 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаар нэмэлт өрчлөлт оруулсан. Энэ хуулийн дагуу агаарын бохирдлын эсрэг санг байгуулж, агаар бохирдохоос урьдчилан сэргийлэх, бохирдуулах бодисын хаягдлыг багасгах зорилтын хүрээнд Засгийн газраас хэрэгжүүлж байгаа арга хэмжээг санхүүжүүлэх юм.